

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2007 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 118

Улаанбаатар хот

Заавал байлгах нөөцийн хувь хэмжээ, журамд
өөрчлөлт оруулах тухай

“Төв банк /Монголбанк/-ны тухай хууль”-ийн 12 дугаар зүйл, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Монголбанкны Захирлуудын зөвлөлийн 2007 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1.”Заавал байлгах нөөц тогтоож, хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.

~~2.Банкны тогрогийн болон валютын Заавал байлгах нөөцийн доод хэмжээг тус бүр 5 хувиар тогтоож, 2007 оны 3 дугаар сарын 28 ны өдрөөс эхлэн мөрдөгүй.~~

[МБЕ-ийн 2007 оны 12 сарын 13-ны өдрийн 586 тоот тушаалаар хүчингүй.](#)

3.”Заавал байлгах нөөц тогтоож, хяналт тавих журам”-ыг болон түүнд тогтоосон хувь хэмжээг 2007 оны 3 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг банкны захирлуудад даалгасугай.

4.”Заавал байлгах нөөц тогтоож, хяналт тавих журам”-ыг мөрдүүлэх талаар банкны холбогдох ажилтнуудад сургалт явуулахыг Мөнгөний бодлого, судалгааны газар /Р.Саранцэцэг/-т үүрэг болгосугай.

5.Банкуудаас ирүүлсэн 14 хоногийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн мэдээний үнэн зөв эсэхэд хяналт тавьж, зөрчсөн банкинд холбогдох арга хэмжээ авч байхыг Хяналт шалгалтын газар /Ж.Ганбаатар/-т үүрэг болгосугай.

6.Энэ тушаал гарсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2001 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 181, 2005 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 397 тоот тушаалыг тус тус хүчингүйд болсонд тооцсугай.

7.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыгн Мөнгөний бодлого, судалгааны газар /Р.Саранцэцэг/, Дотоод аудитын газар /М.Амгалан/-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

А.БАТСҮХ

ЗААВАЛ БАЙЛГАХ НӨӨЦ ТООЦОЖ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монголбанкнаас мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангуулах зорилгоор банкны бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд ноогдох заавал байлгах нөөцийн хэмжээг тогтоож, биелэлтэд нь хяналт тавихад энэхүү журмыг мөрдөнө.

2. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

"Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө" гэж энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан, тухайн банкны тэнцэлд байршсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, Засгийн газрын харилцах, хадгаламж болон бусад эх үүсвэр болох төгрөгийн ба валютын дансдын (төгрөгийн илэрхийллээр) үлдэгдлийг хэлнэ.

"Заавал байлгах нөөцийн хувь хэмжээ" гэдэгт банкны бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөөс заавал байлгах нөөц тооцохоор Монголбанкнаас тогтоосон хувь хэмжээг ойлгоно.

"Заавал байлгах нөөцийн хэмжээ" гэж банкны бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн дундаж үлдэгдэл болон заавал байлгах нөөцийн хувь хэмжээг үндэслэн Монголбанкнаас тогтоосон дүнг хэлнэ.

"Бэлэн нөөц" гэж тухайн банкны Монголбанкин дахь төгрөгийн харилцах дансны үлдэгдлийг хэлнэ.

"Бэлэн нөөц валютаар" гэдэгт банкны касс дахь валют, валютын чек болон Монголбанкин дахь валютын харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдлийн төгрөгөөр илэрхийлэгдсэн дүнг ойлгоно.

"Тайлант хугацаа" гэдэг нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн дундаж үлдэгдлийн мэдээллийг хамруулах хугацааг хэлэх бөгөөд энэ нь 2 долоо хоног байна.

"Заавал байлгах нөөцийг хангах хугацаа" гэдгийг заавал байлгах нөөцийн хэмжээг мөрдөх Монголбанкнаас тогтоосон хугацаа гэж ойлгох бөгөөд энэ нь 2 долоо хоног байна.

3. Монголбанкнаас Монгол улсад банкны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан бүх банк энэхүү журмыг дагаж мөрдөнө.

4. Банк нь Монголбанкнаас тогтоосон хувь хэмжээний дагуу бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн тодорхой хэсгийг заавал байлгах нөөцөд төвлөрүүлнэ.

~~5. Банк нь заавал байлгах нөөцийг төгрөгөөр болон валютаар тус тусад нь хангаж ажиллана.~~

5. Банк нь заавал байлгах нөөцийг төгрөгөөр болон валютаар тус тусад нь хангаж ажиллах бөгөөд заавал байлгах нөөцийн шаардлагын 50-аас доошгүй хувьтай тэнцэх хөрөнгийг Монголбанкин дахь төгрөгийн болон валютын харилцах дансандаа өдөр бүрийн гүйлгээний эцэст тус тус байршуулна.

[МБЕ-ийн 2009 оны 03 сарын 19-ны өдрийн 162 тоот тушаалаар өөрчлөв.](#)

6.Төгрөгөөр болон валютаар байршуулах заавал байлгах нөөцийн хувь хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтооно.

~~7.Заавал байлгах нөөцийг хангах зорилгоор банкнаас Монголбанкин дахь харилцах дансандаа төвлөрүүлж буй үлдэгдэлд хүү төлөхгүй.~~

7.Монголбанк банкны заавал байлгах нөөцийн хэмжээнд хүү төлж болно. Хүүгийн хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтоох бөгөөд заавал байлгах нөөцийн шаардлагыг хангаагүй банкинд хүү төлөхгүй.

МБЕ-ийн 2009 оны 03 сарын 19-ны өдрийн 162 тоот тушаалаар өөрчлөв.

8.Тайлант хугацаа нь долоо хоногийн Лхагва гаригаас эхлэн хуанлийн өдөр бүрийг хамарч, 2 дахь долоо хоногийн Мягмар гаригийн дүнг оруулснаар дуусгавар болно. Ажлын бус өдрийн дансны үлдэгдлийг өмнөх ажлын өдрийн дүнгээр тооцно.

9.Заавал байлгах нөөцийг мөрдөх хугацаа нь мөн 2 долоо хоногийн турш хуанлийн өдөр бүрийг хамрах бөгөөд долоо хоногийн Лхагва гаригаас эхлэн 2 дахь долоо хоногийн Мягмар гаригийг оруулснаар дуусгавар болно.

10.Банкны орон нутаг дахь салбарын татан төвлөрүүлсэн хөрөнгийн мэдээг Улаанбаатар хотод байрлах тухайн банкны төвөөс Монголбанкинд ирүүлнэ.

11.Банк Монголбанкнаас тогтоосон заавал байлгах нөөцийг өдрийн турш төлбөр тооцоонд хэрэглэж болох боловч өдрийн эцэст заавал байлгах нөөцийн шаардлагыг хангасан байна.

МБЕ-ийн 2009 оны 05 сарын 26-ны өдрийн 298 тоот тушаалаар нэмэв.

Хоёр. Төгрөгөөр заавал байлгах нөөцийн хэмжээг тогтоож, хангалтыг тооцох.

11.Банкны заавал байлгах нөөцийг тодорхойлохдоо тухайн банкны Монголбанкин дахь харилцах дансны өдөр тутмын төгрөгийн үлдэгдлийн доод хэмжээг тогтоох замаар гүйцэтгэнэ.

~~12.Банк нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайлант хугацааны дундаж үлдэгдлийн мэдээг энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу үйлдэж, тайлант хугацаа дууссанаас хойшхи 7 хоногт багтаан Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар /цаашид Мөнгөний бодлого, судалгааны газар гэх/ -т ирүүлнэ.~~

12.Банк нь заавал байлгах нөөцийг тооцох бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайлант хугацааны дундаж үлдэгдлийн мэдээг энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу үйлдэж, тайлант хугацаа дууссанаас хойш ажлын 5 өдөрт багтаан Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар (цаашид Мөнгөний бодлого, судалгааны газар гэх) -т хүргүүлнэ.

МБЕ-ийн 2009 оны 03 сарын 19-ны өдрийн 162 тоот тушаалаар өөрчлөв.

12.Банк нь заавал байлгах нөөцийг тооцох бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайлант хугацааны дундаж үлдэгдлийн мэдээг энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу үйлдэж, тайлант хугацаа дууссанаас хойш ажлын 5 өдөрт багтаан Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар /цаашид Мөнгөний бодлого, судалгааны газар гэх/-т банк хоорондын цахим арилжааны системээр болон хэвлэмэл хэлбэрээр хүргүүлнэ.

МБЕ-ийн 2011 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 1 дүгээр тушаалаар өөрчлөн найруулав.

13.Мөнгөний бодлого, судалгааны газар нь банкнаас ирүүлсэн мэдээг үндэслэн 2 дугаар хавсралтын дагуу тухайн банкны заавал байлгах нөөц буюу Монголбанкин дахь төгрөгийн харилцах дансанд тайлант хугацаа эхэлснээс 3 дахь 14 хоногт өдөр тутам байх үлдэгдлийн доод хэмжээг тогтооно. Үүнд:

а) Заавал байлгах нөөц тооцох бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайлант хугацааны дундаж үлдэгдлийг банкнаас ирүүлсэн 1 дүгээр хавсралтын 3 дугаар баганын дүнгээр авна.

б) 13 дугаар зүйлийн "а"-д заасан заавал байлгах нөөц тооцох бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайлант хугацааны дундаж үлдэгдлээс Монголбанкнаас тогтоосон төгрөгөөр заавал байлгах нөөцийн хувь хэмжээгээр тооцож, банкны заавал байлгах нөөц буюу Монголбанкин дахь төгрөгийн харилцах дансанд байх үлдэгдлийн доод хэмжээг тогтооно.

в) Энэ зүйлийн "б"-д заасны дагуу тооцсон банкны заавал байлгах нөөц буюу Монголбанкин дахь төгрөгийн харилцах дансанд байх үлдэгдлийн доод хэмжээг Мөнгөний бодлого, судалгааны газрын захирлаар батлуулан заавал байлгах нөөцийг мөрдөх хугацаанд мөрдүүлэхээр банкуудад уг хугацааг эхлэхээс өмнөх 6 хоногийн дотор багтаан хүргүүлнэ.

в) Энэ зүйлийн "б"-д заасны дагуу тооцсон банкны заавал байлгах нөөц буюу Монголбанкин дахь төгрөгийн харилцах дансанд байх үлдэгдлийн доод хэмжээг Мөнгөний бодлого, судалгааны газрын захирлаар батлуулж, заавал байлгах нөөцийн шаардлагыг мөрдөх хугацаанаас өмнөх ажлын 4 өдрийн дотор багтаан хүргүүлнэ.

[МБЕ-ийн 2009 оны 03 сарын 19-ны өдрийн 162 тоот тушаалаар өөрчлөв.](#)

14. Мөнгөний бодлого, судалгааны газар нь энэхүү журмын 3 дугаар хавсралтын дагуу банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хангалтын тооцоог банкны системийн хэмжээгээр нэгтгэж хяналт тавина. Үүнд:

Тухайн банкны Монголбанкин дахь төгрөгийн харилцах дансны өдрийн үлдэгдлийг энэ журмын 13 дахь заалтын дагуу банкны харилцах дансанд байлгах аар тогтоосон дундаж үлдэгдэлтэй харьцуулж, тухайн өдрийн заавал байлгах нөөцийн хангалт (илүү, дутууг) -ыг тодорхойлно. Банк нь заавал байлгах нөөцөө хангаж, илүүдэлтэй байвал тэр хэмжээгээр хөрөнгийн чөлөөт эх үүсвэртгйд тооцогдоно.

14. Мөнгөний бодлого, судалгааны газар нь энэхүү журмын 3 дугаар хавсралтын дагуу банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хангалтын тооцоог банкны системийн хэмжээгээр нэгтгэж хяналт тавина. Үүнд: Тухайн банкны Монголбанкин дахь төгрөгийн харилцах дансны өдрийн үлдэгдлийг энэхүү журмын 13 дахь заалтын дагуу банкны харилцах дансанд байлгах аар тогтоосон дундаж үлдэгдэлтэй харьцуулж, тухайн өдрийн заавал байлгах нөөцийн хангалт /илүү, дутууг/-ыг тодорхойлно. Банк нь төгрөгийн заавал байлгах нөөцөө хангаж, илүү гарсан хэмжээгээр валютын заавал байлгах нөөцийн шаардлагын 50 хүртэл хувийг хангаж болно.

[МБЕ-ийн 2014 оны 12 сарын 25-ны өдрийн А-207 дугаар тушаалаар өөрчлөв.](#)

15. Мөнгөний бодлого, судалгааны газар нь банкны заавал байлгах нөөцийн өдөр бүрийн хангалтын тооцоог энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу тухайн өдрийн байдлаар болон өссөн дүнгээр тодорхойлж 4 дүгээр хавсралтын дагуу нэгтгэж мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглана.

Гурав. Валютаар заавал байлгах нөөцийн хэмжээг тогтоож, хангалтыг тооцох

Банкны валютаар заавал байлгах нөөцийг тооцохдоо 1 дүгээр хавсралтын дагуу банкнаас ирүүлсэн мэдээг үндэслэн 2 дугаар хавсралтад заасны дагуу тооцно. Үүнд:

а) Валютаар заавал байлгах нөөц тооцох бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайлант хугацааны дундаж үлдэгдлийг банкнаас ирүүлсэн 1 дүгээр хавсралтын 3 дугаар баганын дүнгээр авна.

б) 16 дугаар зүйлийн "а"-д заасан валютаар заавал байлгах нөөц тооцох бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайлант хугацааны дундаж үлдэгдлээс Монголбанкнаас тогтоосон валютаар заавал байлгах нөөцийн хувь хэмжээгээр тооцож, тайлант хугацаа эхэлсэнээс 3 дахь 14 хоногт мөрдөх банкны заавал байлгах нөөц буюу Монголбанкин дахь валютын харилцах дансанд байх үлдэгдлийн доод хэмжээг тогтооно.

~~в) Энэ зүйлийн "б" д заасны дагуу тооцсон банкны валютаар заавал байлгах нөөцийн хэмжээг Мөнгөний бодлого, судалгааны газрын захирлаар батлуулан заавал байлгах нөөц мөрдөх хугацаанд мөрдүүлэхээр уг хугацааг эхлэхээс өмнөх 6 хоногийн дотор банкуудад мэдэгдэнэ.~~

в) Энэ зүйлийн "б"-д заасны дагуу тооцсон банкны валютын заавал байлгах нөөцийн хэмжээг Мөнгөний бодлого, судалгааны газрын захирлаар батлуулж, заавал байлгах нөөцийг мөрдөх хугацаанаас өмнөх ажлын 4 өдрийн дотор багтаан хүргүүлнэ.

[МБЕ-ийн 2009 оны 03 сарын 19-ны өдрийн 162 тоот тушаалаар өөрчлөв.](#)

~~17. Мөнгөний бодлого, судалгааны газар нь энэхүү журмын 3 дугаар хавсралтын дагуу банкны валютаар заавал байлгах нөөцийн хангалтыг тайлант хугацааны дундаж үлдэгдлээр тооцно. Үүнд:~~

17. Мөнгөний бодлого, судалгааны газар нь энэхүү журмын 3 дугаар хавсралтын дагуу банкны валютын заавал байлгах нөөцийн хангалтыг тайлант хугацааны турш өдрөөр болон дундаж үлдэгдлээр тооцож, банкны системийн хэмжээгээр нэгтгэж, хяналт тавина. Үүнд:

[МБЕ-ийн 2009 оны 03 сарын 19-ны өдрийн 162 тоот тушаалаар өөрчлөв.](#)

~~а) Валютын заавал байлгах нөөцийг Монголбанкин дахь валютын харилцах дансны дундаж үлдэгдэл болон кассе дахь бэлэн валютаар хангуулж болох бөгөөд үүнд кассын эзлэх хувийн жин 50 хувиас ихгүй байна.~~

а) Валютын заавал байлгах нөөцийг Монголбанкин дахь валютын харилцах дансны үлдэгдлээр хангуулна.

[МБЕ-ийн 2011 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 1 дүгээр тушаалаар өөрчлөн найруулав.](#)

~~б) Монголбанкнаас тогтоосон валютаар заавал байлгах нөөцийг тухайн банкны Монголбанкин дахь валютын харилцах дансны үлдэгдэл, кассе байгаа бэлэн валют, чекийн дүнтэй харьцуулан валютаар заавал байлгах нөөцийн хангалт (илүү, дутуу) -ыг тодорхойлно.~~

~~**б) Монголбанкнаас тогтоосон валютаар заавал байлгах нөөцийг тухайн банкны Монголбанкин дахь валютын харилцах дансны үлдэгдлийн дүнтэй харьцуулан валютаар заавал байлгах нөөцийн хангалт /илүү, дутуу/-ыг тооцно. Банк нь валютын заавал байлгах нөөцөө хангаж, илүү гарсан хэмжээгээр тогрогийн заавал байлгах нөөцийн шаардлагын 50 хүртэл хувийг хангаж болно.**~~

[МБЕ-ийн 2014 оны 12 сарын 25-ны өдрийн А-207 дугаар тушаалаар өөрчлөв.](#)

б) Монголбанкнаас тогтоосон валютаар заавал байлгах нөөцийг тухайн банкны Монголбанкин дахь валютын харилцах дансны үлдэгдлийн дүнтэй харьцуулан валютаар заавал байлгах нөөцийн хангалт /илүү, дутуу/-ыг тооцно.

[МБЕ-ийн 2015 оны 6 сарын 30-ны өдрийн А-102 дугаар тушаалаар өөрчлөв.](#)

Дөрөв. Монголбанкнаас явуулах хяналт, шалгалт, авах арга хэмжээ

18. Мөнгөний бодлого, судалгааны газар нь заавал байлгах нөөцийн биелэлтэд банк тус бүрээр хяналт тавьж ажиллана.

19. Заавал байлгах нөөцийг дутагдуулсан банкинд Монголбанк дараах арга хэмжээг авна.
Үүнд:

а) Заавал байлгах нөөцийг дутагдуулсан банкинд торгууль ногдуулах бөгөөд торгуулийн дээд хязгаар нь тухайн үед Монголбанкнаас банкинд олгох хамгийн өндөр хүүтэй зээлийн хүү дээр таван нэгж хувийг нэмсэнээс илүүгүй байна.

б) Ноогдуулсан торгуулийг тус банкны Монголбанкн дахь харилцах данснаас шууд суутгаж авна.

~~20. Төгрөг, валютын заавал байлгах нөөцийн шаардлагыг хангаагүй дутагдуулсанд ногдуулсан торгуулийг 14 хоногөөр тооцож Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлуулан банк бүрт 5 дугаар хавсралтаар мэдэгдэнэ.~~

20. Төгрөг, валютын заавал байлгах нөөцийн шаардлагыг хангаагүй дутагдуулсанд ногдуулах торгуулийг өдрөөр болон 14 хоногөөр тооцож Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлуулан банк бүрт 5 дугаар хавсралтын дагуу мэдэгдэнэ.

[МБЕ-ийн 2009 оны 03 сарын 19-ны өдрийн 162 тоот тушаалаар өөрчлөв.](#)

~~21. Заавал байлгах нөөц дутагдуулсны торгуулийг Монголбанкн дахь харилцах данснаас нь суутгаж авсан тухай мэдэгдлийг Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газраас холбогдох банкинд нь тухай бүр мэдэгдэнэ.~~

21. Заавал байлгах нөөц дутагдуулсны торгуулийг Монголбанкн дахь харилцах данснаас суутгаж авсан тухай мэдэгдлийг Монголбанкны Бүртгэл тооцоо, мэдээллийн технологийн газраас холбогдох банкинд нь тухай бүр мэдэгдэнэ.

[МБЕ-ийн 2009 оны 03 сарын 19-ны өдрийн 162 тоот тушаалаар өөрчлөв.](#)

22. Мөнгөний бодлого, судалгааны газар заавал байлгах нөөцийн доод хэмжээг 3 сараас дээш хугацаагаар үргэлжлүүлэн хангаагүй банкинд ногдуулах албадлагын арга хэмжээний тухай санал боловсруулан Монголбанкны Захирлуудын зөвлөлд тавьж шийдвэрлүүлнэ.

23. Заавал байлгах нөөц тооцоход шаардагдах, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн дансдын үлдэгдлийн мэдээг банкнаас хугацаанд нь үнэн зөв гаргаж байгаа эсэхэд Хяналт шалгалтын газар, Мөнгөний бодлого, судалгааны газар хяналт тавьж ажиллана.

24. Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн дансдын үлдэгдлийн тайлант хугацааны мэдээг худал, ташаа гаргаж ирүүлсэн банкинд Банкны тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасан хариуцлагын арга хэмжээг авна.

25. Мөнгөний бодлого, судалгааны газраас банкны заавал байлгах нөөцийн хангалт, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын талаар Мөнгөний бодлого, судалгааны газар Монголбанкны Ерөнхийлөгчид тогтмол танилцуулна.

“Заавал байлгах нөөц тооцож, хяналт тавих журам”-ын
1 дүгээр хавсралт

... банкны заавал байлгах нөөц тооцох бусдаас татан төвлөрүүлсэн
хөрөнгийн ... оны ... сарын ... нээе ... ний өдрийн хоорондох 14 хоногийн мэдээ

/мянган төгрөгөөр/

	Д/Д	Үзүүлэлтүүд	Хуанлийн өдрүүд, (1 –14) р өдөр			14 хоногийн дундаж үлдэгдэл	
			2				3
			1-дэх өдөр	2-дах өдөр	14-дэх өдөр		
Төгрөгөөр татан төвлөрүүлсэн хөрөнгө	1	Улсын байгууллага, хувийн секторын харилцах дансны үлдэгдэл / 211100, 212100/					
	2	Улсын байгууллага, хувийн секторын хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл /222110, 222210/					
	3	Улсын байгууллага, хувийн секторын хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл /221110, 221210/					
	4	Иргэд, гадаадын оршин суугч, оршин суугч бусын харилцах дансны үлдэгдэл /213100, 215100 /					
	5	Иргэд, гадаадын оршин суугч, оршин суугч бусын хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл /222310, 222461/					
	6	Иргэд, гадаадын оршин суугч, оршин суугч бусын хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл /221310, 221610/					
	7	Санхүүгийн байгууллагуудын харилцах дансны үлдэгдэл /214110, 214120, 214210, 214220, 214310, 214320, 214410, 214420, 231510*/					
	8	Санхүүгийн байгууллагуудын хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл /221421,221422,222411, 222412,222431, 222432, 222441, 222442, 231520*/					
	9	Санхүүгийн байгууллагуудын хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл /221411,221412, 221431, 221432, 221441, 221442, 222421, 222422/					
	10	Төрийн сангийн болон орон нутгийн төсөвт байгууллагын харилцах дансны үлдэгдэл /216100/					
	11	Төрийн сангийн болон орон нутгийн төсөвт байгууллагын хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл /222471/					
	12	Төрийн сангийн болон орон нутгийн төсөвт байгууллагын хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл /221710 /					
	13	Бусад эх үүсвэрийн хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл /222481/					

	14	Бусад эх үүсвэрийн хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл /221810/				
	15	Бусад эх үүсвэрийн дансдын үлдэгдэл /217100, 241100, 241310, 241400, 241200*, 242000*, 243000*, 223600*, 223900*, 246100*, 246300*, 246400*/				
	1	Улсын байгууллага, хувийн секторын харилцах дансны үлдэгдэл /211200, 212200/				
	2	Улсын байгууллага, хувийн секторын хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл /222120, 222220/				

	3	Улсын байгууллага, хувийн секторын хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл /221220, 221120/				
	4	Иргэд, гадаадын оршин суугч, оршин суугч бусын харилцах дансны үлдэгдэл /213200, 215200/				
	5	Иргэд, гадаадын оршин суугч, оршин суугч бусын хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл /222320, 222462/				
	6	Иргэд, гадаадын оршин суугч, оршин суугч бусын хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл /221320, 221620/				
	7	Санхүүгийн байгууллагуудын харилцах дансны үлдэгдэл /214130, 214140, 214230, 214240, 214330, 214340, 214430, 214440, 231510**/				
	8	Санхүүгийн байгууллагуудын хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл /222413, 222414, 222423, 222424, 222433, 222434, 222443, 222444, 231520**/				
	9	Санхүүгийн байгууллагуудын хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл /221413, 221414, 221423, 221424, 221433, 221434, 221443, 221444, 231400/				
	10	Төрийн сангийн болон орон нутгийн төсөвт байгууллагын харилцах дансны үлдэгдэл /216200/				
	11	Төрийн сангийн болон орон нутгийн төсөвт байгууллагын хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл /222472/				
	12	Төрийн сангийн болон орон нутгийн төсөвт байгууллагын хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл /221720/				
	13	Бусад хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл /222482/				
	14	Бусад хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл /221820/				
	15	Бусад эх үүсвэрийн дансдын үлдэгдэл /217200, 241320, 241100*, 241400**, 241200**, 242000**, 243000**, 223600**, 223900**, 246100**, 246300**, 246400**/				
Валютын касс	+	Банкны касс дахь бэлэн валют, чекийн үлдэгдэл /112000, 113200, /				

Жич: Ажлын бус өдрийн дансны үлдэгдлийг түүний өмнөх ажлын өдрийн дансны үлдэгдлээр тооцно

* Тус дансдын тогрогийн дүн


** Тус дансдын валютын дүн

[МБЕ-ийн 2014 оны 2 сарын 19-ний өдрийн А-35 дугаар тушаалаар өөрчлөв.](#)

Монголбанкны Ерөнхийлөгчийн
2014 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн
А-35 дугаар тушаалын хавсралт

"Заавал байлгах нөөц тооцож, хяналт тавих журам"-ын
1 дүгээр хавсралт

... банкны заавал байлгах нөөц тооцох бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн ... оны
... сарын ...-нээс ... -ний өдрийн хоорондох 14 хоногийн мэдээ



(мянган төгрөгөөр)

	Д/ Д	Үзүүлэлтүүд	Хуанлийн өдрүүд, (1- 14)-р өдөр				14 хоногийн дундаж үлдэгдэл
			1 дэх өдөр	2 дах өдөр	...	14 дэх өдөр	
		1	2				3
Төгрөгөөр татан төвлөрүүлсэн хөрөнгө	1	Улсын байгууллага, хувийн секторын харилцах дансны үлдэгдэл / 211100, 212100/					
	2	Улсын байгууллага, хувийн секторын хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл / 222110, 222210/					
	3	Улсын байгууллага, хувийн секторын хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл /221110, 221210/					
	4	Иргэд, гадаадын оршин суугч, оршин суугч бусын харилцах дансны үлдэгдэл /213100, 215100 /					
	5	Иргэд, гадаадын оршин суугч, оршин суугч бусын хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл /222310, 222461/					
	6	Иргэд, гадаадын оршин суугч, оршин суугч бусын хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл /221310, 221610/					
	7	Санхүүгийн байгууллагуудын харилцах дансны үлдэгдэл /214110, 214120, 214210, 214220, 214310, 214320, 214410, 214420, 231510*/					
	8	Санхүүгийн байгууллагуудын хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл / 221421, 221422, 222411, 222412, 222431, 222432, 222441, 222442, 231520*/					
	9	Санхүүгийн байгууллагуудын хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл / 221411, 221412, 221431, 221432, 221441, 221442, 222421, 222422/					
	10	Төрийн сангийн болон орон нутгийн төсөвт байгууллагын харилцах дансны үлдэгдэл /216100/					
	11	Төрийн сангийн болон орон нутгийн төсөвт байгууллагын хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл /222471/					
	12	Төрийн сангийн болон орон нутгийн төсөвт байгууллагын хугацаатай					

		хадгаламжийн дансны үлдэгдэл /221710 /						
	13	Бусад эх үүсвэрийн хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл / 222481/						
	14	Бусад эх үүсвэрийн хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл /221810/						
	15	Бусад эх үүсвэрийн дансдын үлдэгдэл /217100, 241100*, 241310, 241400*, 241200*, 242000*, 243000*, 223600*, 223900*, 246100*, 246300*, 246400*/						
Валютаар татан төвлөрүүлсэн хөрөнгө	1	Улсын байгууллага, хувийн секторын харилцах дансны үлдэгдэл /211200, 212200/						
	2	Улсын байгууллага, хувийн секторын хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл /222120, 222220/						
	3	Улсын байгууллага, хувийн секторын хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл /221220, 221120/						
	4	Иргэд, гадаадын оршин суугч, оршин суугч бусын харилцах дансны үлдэгдэл /213200, 215200/						
	5	Иргэд, гадаадын оршин суугч, оршин суугч бусын хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл /222320, 222462/						
	6	Иргэд, гадаадын оршин суугч, оршин суугч бусын хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл /221320, 221620/						
	7	Санхүүгийн байгууллагуудын харилцах дансны үлдэгдэл /214130, 214140, 214230, 214240, 214330, 214340, 214430, 214440, 231510**/						
	8	Санхүүгийн байгууллагуудын хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл /222413, 222414, 222423, 222424, 222433, 222434, 222443, 222444, 231520**/						
	9	Санхүүгийн байгууллагуудын хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл /221413, 221414, 221423, 221424, 221433, 221434, 221443, 221444, 231400/						
	10	Төрийн сангийн болон орон нутгийн төсөвт байгууллагын харилцах дансны үлдэгдэл /216200/						
	11	Төрийн сангийн болон орон нутгийн төсөвт байгууллагын хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл /222472/						
	12	Төрийн сангийн болон орон нутгийн төсөвт байгууллагын хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл /221720/						
	13	Бусад хугацаагүй хадгаламжийн дансны үлдэгдэл /222482/						
	14	Бусад хугацаатай хадгаламжийн дансны үлдэгдэл /221820/						
	15	Бусад эх үүсвэрийн дансдын үлдэгдэл /217200, 241320, 241100**, 241400**, 241200**, 242000**, 243000**, 223600**, 223900**, 246100**, 246300**, 246400**/						
Вал юты н касс	1	Банкны касс дахь бэлэн валют, чекийн үлдэгдэл/112000, 113200, /						

Жич: Ажлын бус өдрийн дансны үлдэгдлийг түүний өмнөх ажлын өдрийн дансны үлдэгдлээр тооцно.

* - Тус дансдын төгрөгийн дүн

** - Тус дансдын валютын дүн

*** - Тус дансдын 3 жил буюу түүнээс урт хугацаатай бонд хэлбэрээр татсан гадаад валютын дүн хамаарахгүй.

“Заавал байлгах нөөц, тооцож, хяналт тавих журам”-ын
2 дугаар хавсралт

Банкуудын заавал байлгах нөөцийн тооцоо
...оны ...-р сарын...оны ...-р сарын...

(мянган төгрөгөөр)

Д/д	Банкууд	ТӨГРӨГӨӨР			ВАЛЮТААР		
		Заавал байлгах нөөц тооцох дундаж үлдэгдэл (1 дүгээр хавсралтын 3 дугаар баганын дүн)	Заавал байлгах нөөцийн хувь хэмжээ	Заавал байлгах нөөцийн хэмжээ буюу банкнаас Монголбанкн дахь төгрөгийн харилцах дансандаа байлгавал зохих үлдэгдлийн доод хэмжээ	Валютаар заавал байлгах нөөц тооцох дундаж үлдэгдэл (1 дүгээр хавсралтын 3 дугаар баганын дүн)	Валютаар заавал байлгах нөөцийн хувь хэмжээ	Валютаар заавал байлгах нөөцийн хэмжээ
0	1	2	3	$4=2*3/100$	5	6	$7=5*6/100$
1							
2							
3							
4							
...							

Тооцоо хийсэн эдийн засагч(нэр)

“Заавал байлгах нөөц тооцож, хяналт тавих журам”-ын
3 дугаар хавсралт

.....банкны Заавал байлгах нөөцийн хангалтын тооцоо

...оны ...-р сарын-ээс ...оны ...-р сарын

(мянган төгрөгөөр)

	ТӨГРӨГӨӨР				ВАЛЮТААР		
Тайлант хугацааны хуанлийн өдрүүд	Банкны Монголбанкин дахь харилцах дансанд байлгавал зохих үлдэгдлийн доод хэмжээ (2 дугаар хавсралтын 4 дүгээр багана)	Бэлэн нөөц буюу Монголбанкин дахь харилцах дансны үлдэгдэл	Нөөцийн хангалт тухайн өдрийн дүнгээр илүү (+) дутуу (-)	Нөөцийн хангалт өссөн дүнгээр илүү (+) дутуу (-)	Валютаар заавал байлгах нөөцийн хэмжээ (2 дугаар хавсралтын 7 дугаар багана)	Бэлэн нөөц валютаар буюу Монголбанкин дахь валютын харилцах данс	Касс дахь бэлэн валют, чек
0	1	2	3	4	5	6	7
... -р сарын							
... -р сарын							

Тооцоо хийсэн эдийн засагч/нэр/
Хянасан МБСГ-ын захирал...../нэр/

“Заавал байлгах нөөц тооцож, хяналт тавих журам”-ын
4 дүгээр хавсралт

Банкуудын төгрөгийн болон валютын заавал байлгах нөөцийн хангалтын нэгдсэн тооцоо

ТӨГРӨГӨӨР

<i>Сар, өдөр</i>	... банк		... банк		... гэх мэт	ДҮН	
	тухайн өдрийн	Өссөн дүнгээр	тухайн өдрийн	Өссөн дүнгээр		тухайн өдрийн	өссөн дүнгээр
... –р сарын ...							
... –р сарын ...							

ВАЛЮТААР

<i>Сар, өдөр</i>	... банк		... банк		... гэх мэт	ДҮН	
	тухайн өдрийн	Өссөн дүнгээр	тухайн өдрийн	Өссөн дүнгээр		тухайн өдрийн	өссөн дүнгээр
... –р сарын ...							
... –р сарын ...							

Хянасан МБСГ-ын захирал...../нэр/
Тооцоо хийсэн эдийн засагч...../нэр/

“Заавал байлгах нөөц тооцож, хянал тавих журам”-ын
5 дугаар хавсралт

.....банкны заавал байлгах нөөцийг дутагдуулсанд ногдуулсан торгууль

...оны...-р сарын ...-ээс.....оны...сарын.....

(мянган төгрөгөөр)

Д/Д	Банкууд	Заавал байлгах нөөцийг дутагдуулсан хэмжээ		Заавал байлгах нөөцийг дутагдуулсанд ногдуулсан торгууль		БҮГД
		Төгрөгөөр	Валютаар	Төгрөгөөр	Валютаар	
1						
2						
3						
...						

Хянасан МБСГ-ын захирал...../нэр

Тооцоо хийсэн эдийн засагч/нэр/